

АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 02

№	Сургалтын чиглэл	Сургалтад оролцогчид	Сургалтын хугацаа	Хугацаа, хоногоор	Сургалтад хамрагдах ажилтны тоо	Сургалтын хэлбэр	Хэрэгжилт
---	------------------	----------------------	-------------------	-------------------	---------------------------------	------------------	-----------

1	2	3	4	5	6	7	8
Нэг. Ажлын байран дахь сургалт							
1.	Архивын ерөнхий газраас зохион байгуулах албан хэрэг хөтлөлтийн цахим сургалтад албан хаагчдыг хамруулах	Байгууллагын дарга, хэлтсийн дарга, 15 албан хаагч	Архивын ерөнхий газрын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу	Хөтөлбөрт заасан хугацаагаар	15 албан хаагч	Цахим	-Архангай аймгийн Засаг даргын тамгын газар Архивчдын хөгжил сургалт арга зүйн төвтөй хамтран зохион байгуулсан 2025 оны 02 дугаар сарын 21-22-ний өдрүүдэд 4 албан хаагч танхимын сургалтад, -Архивын ерөнхий газраас зохион байгуулсан албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, MNS 5140-1:2021, MNS 5140-2:2021, MNS 5140-3:2021 цахим сургалтад 11 албан хаагчийг хамруулсан. Нийт 15 албан хаагчийг сургалтад хамруулсан.
2.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Ус, цаг уурын өртөө, харуулын ээлжийн техникч, харуулын ажиглагч нар болон бусад ажилтан	Тухай бүр	Төлөвлөсөн хугацаагаар	68	Танхим болон цахим	Давхардсан тоогоор 125 удаа танхим болон цахимаар зааварчилгаа өгсөн.
3.	Орлон ажиглагч бэлтгэх сургалт	Орлон ажиллах иргэд	Тухай бүр	10 хүртэл хоног	Тухай бүр	Танхим	Хашаат цаг уурын харуулын 1, Цэцэрлэг цаг уурын харуулын 1 Цэцэрлэг өртөөнд 1, Эрдэнэмандал өртөө 4, нийт 7 иргэнийг ажлын 10 хоногийн хугацаанд мэргэжлийн чиглэл олгох сургалтад хамруулсан.

4.	Чиглүүлэх болон дадлагажуулах сургалт	Шинээр ажилд орж байгаа болон шилжин ажиллаж байгаа ажилтан	Тухай бүр	5 хоног	Тухай бүр	Танхим	Хашаат цаг уурын харуулд 1 иргэнийг ажлын 10 хоногийн хугацаанд чиглүүлэх сургалтад хамруулсан.
5.	Албан хаагчдыг монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах, албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах сургалт зохион байгуулах	Байгууллагын ажилтан, албан хаагчид	Тухай бүр	Цахим болон танхимаар	68	68	Нийт албан хаагчид Үндэсний монгол бичгийн мэдлэг дээшлүүлэх анхан шатны сургалт (5 цаг, 31 минут)-ыг цахимаар судалж гэрчилгээ авсан.
Хоёр. Мэргэшүүлэх сургалт							
4.	Мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Сумдын өртөөдийн ээлжийн техникч, Гадаргын ус судлал, Хөдөө аж ахуйн цаг уурын харуулын ажиглагч нар	Тухай бүр	2	43	Танхим болон цахим	03 дугаар сарын 21-нд ус судлалын 10 харуулын ажиглагч нарт танхимын сургалтыг хийсэн. 04 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд шинээр орсон болон ажил сайжруулах шаардлагатай 7 цаг уурын харуулын ажиглагч нарт танхимаар сургалт зохион байгуулсан.
5.	ЦУОШГ-ын сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулах сургалтад оролцох	Хамаарал бүхий ажилтан, албан хаагч	Тухай бүр	Төлөвлөсөн хугацаагаар	Хамаарал бүхий ажилтан, албан хаагч	Танхим болон цахим	БОХЗТЛ-оос зохион байгуулсан Шалгалт тохируулгийн ажилтны үнэмлэх сунгах сургалтад 04 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд ЦУОТХ-ийн дарга Д.Их-Оюун, 04 дүгээр сарын 07-08, 14-15-ны өдрүүдэд Пиротехникийн нөхцөлд тэсрэх материалтай харьцах эрх сунгах сургалтад технологич инженер Ш.Отгонсамбуу, техникч-жолооч Э.Бадрах нарыг тус тус оролцуулсан. 2025 оны 05 дугаар сарын 23-нд Иргэний агаарын тээвэрт цаг агаарын мэдээгээр үйлчлэх анхан шатны сургалтыг урьдчилан мэдээлэхийн инженерүүдтэй хамтран зохион байгуулсан. БНСУ-д 2025 оны 8 дугаар сарын 25-29-нд зохион байгуулагдсан “Installation of integrated weather observation data management

[illegible]

8.	Аймгийн ЗДТГ, бусад төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн сургалт	Хамаарал бүхий ажилтан, албан хаагч	Сургалт зохион байгуулагдсан тухай үед нь оролцох	Тухайн сургалтын хугацаагаар	Тухайн сургалтад оролцох хүний тоогоор	Танхим болон цахимаар	-01 дүгээр сарын 02, 05 дугаар сарын 01 нд БОУАӨЯ-аас цахимаар зохион байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, санхүү, аудит, хүний нөөцийн чиглэлийн сургалтад 4 албан хаагч хамрагдсан. -Аймгийн ЗДТГ-т “Авилгагүй Архангай” авилгын эсрэг аяны танхимын сургалтад 20 албан хаагч хамрагдсан. Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулагдсан “Авилагын эсрэг”, -Татварын ерөнхий газраас зохион байгуулагдсан “Хөх монгол Хөх туг” аяны хүрээнд, -“Байгалийн баялгийн 34-50 хувийг иргэн бүрт” уулзалт, -“Архив, албан хэрэг хөтлөлтийн чадавхжуулах” сургалт; -Аймгийн Засаг даргын тамгын газарт “Авлигагүй Архангай” авилгын эсрэг аяны хүрээнд танхимын сургалт, -04 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Хангайн бүсийн өргөтгөсөн хуралдаанд; 2025 оны 04 дүгээр сарын 25-нд Тариаланчдын зөвлөгөөнд оролцов. -2025 оны 05 дугаар сарын 01-нд Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, байгалийн менежментийн хөтөлбөрт оролцов. -АЗДТГ-аас 02 дугаар сарын 13-14-нд зохион байгуулсан “Албан бичиг хос бичгээр хөтлөх, байгууллагын архивын ажлыг дүгнэх” танхимын сургалтад 5 албан хаагч оролцсон. 05 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал”
----	--	-------------------------------------	---	------------------------------	--	-----------------------	---

							Хангайн бүсийн зөвлөгөөнд 1 албан хаагч хамрагдсан. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга, ерөнхий нягтлан бодогч нарыг 10 дугаар сарын 15-16-нд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем”-ийн сургалтад хамруулсан. ТА3-өөс зохион байгуулж байгаа 7:4:10 сургалт мэдээллийн 4 удаагийн сургалтад албан хаагчдыг хамрууллаа.
--	--	--	--	--	--	--	---

9.	ЦУОШГ болон аймгуудын УЦУОШТ-өөс зохион байгуулах сургалтууд	Хамаарал бүхий ажилтан, албан хаагч	Сургалт зохион байгуулагдсан тухай бүр нь оролцох	Тухайн сургалтын хугацаагаар	Тухайн сургалтад оролцох хүний тоогоор	Танхим болон цахим	ЦУОШГ-аас 01 дүгээр сарын 29-30-нд зохион байгуулсан аймгуудын тайланг хэлэлцэх цахим хэлэлцүүлэгт, байгууллага дээр аймгийн НДХ-ээс 04 дүгээр сарын 21-нд, аймгийн Татварын газраас 01 дүгээр сарын 05- нд зохион байгуулсан сургалтуудад 20 албан хаагч тус тус оролцсон. Урьдчилан мэдээлэхийн инженер Б.Мөнхбулган 06 дугаар сарын 2-ноос 24-ний өдрийг хүртэл нисэхийн цаг уурын төвийн сургалтад хамрагдаж, нисэхэд үйлчлэх эрхийн үнэмлэх авсан. Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженер 06 дугаар сарын 30, 10 дугаар сарын 15- 16-ны өдрүүдэд, мөн инженерийн хамтаар 11 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд агаарын чанарыг хянах автомат суурин багажид гарсан гэмтэл оношлох, шалгах, засвар үйлчилгээг хийхэд чадавхыг сайжруулах, агаарын чанарын дүн мэдээш боловсруулах (Агаар.mn, MAMIS.mn) сургалтад хамрагдсан. Цаг уур, орчны шинжилгээний газраас зохион байгуулсан Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмыг танилцуулах цахим сургалтад нийт 12 албан хаагч оролцлоо.
----	--	--	--	------------------------------------	--	-----------------------	---

Товчилсон нэрийн тайлал :

МҮХ	Мэдээлэл, үйлчилгээний хэлтэс
ЦУОТХ	Цаг уур, орчны технологийн хэлтэс
ЗСААХ	Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар

АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

№	Хийх ажил	Хугацаа	Хэрэгжилт
1	2	3	4
Зорилт 1: Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн гэрээнд заасан эрх, үүрэг, гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах ажлын байр, эрүүл ахуйн нөхцөл, бичиг хэргийн хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд нийцсэн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эд материал, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, мэдээллээр хангах зорилтын хүрээнд:			
1.	Ажлын байрны дотоод орчныг тохижуулж, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Жилдээ	Хөмрөг үүсгэгч архивын өрөөг стандартад нийцүүлэн хаалгыг төмөрлөн, дотор өнгө үзэмжийг сайжруулж, галын аюулгүй байдлыг ханган галын хор, элс, хүрз зэргийг өрөөнд байршуулж, цонхыг битүүмжлэх ажлыг зохион байгуулсан. Мөн төвийн конторын барилгын гадна өнгийг сэргээж, байгууллагын гадна хаягийг стандартын дагуу болгон шинэчилсэн.
2.	Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслээр хангах	Тухай бүр	Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдэд хуваарилсан нөөц пуужингийн хуваарийн дагуу 05 сарын 20-нд Завхан аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга, Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйлчилгээний технологич инженер, техникч-жолооч нар 10 ширхэг пуужинг хүлээлгэн өгсөн. Албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслээр бүрэн хангасан.
Зорилт 2: Албан хаагчдыг хууль тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар бүрэн хангах, хөдөлмөрийн дотоод журамд заасан дэмжлэг, тусламж, тэтгэмжийг үзүүлэх зорилтын хүрээнд:			
1.	Албан хаагчдын цалинг ажилласан жилийг харгалзан нэмэгдүүлэх, мэргэшлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх	Жилдээ	2025 оны 11 дугаар сарын гүйцэтгэлээр төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 66 албан хаагчид 118,507.9 мянган төгрөг, мэргэшлийн зэргийн нэмэгдэл 19 алба хаагчид 22,289.2 мянган төгрөг, ур чадварын нэмэгдэл 44 албан хаагчид 37,977.4 мянган төгрөгийг холбогдох тогтоомжийн олгосон.
2.	Хоол, нийтийн тээврийн унааны зардлыг байгууллагын дотоод журмын дагуу тухайн жилийн төсөвтэй уялдуулан олгох	Жилдээ	Хоол унааны хөнгөлөлтийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу аймгийн төвийн албан хаагчдад өдрийн 15,000-20,000 төгрөгөөр, сумдын албан хаагчдад өдрийн 7,000-10,000 төгрөгөөр тус тус тооцон олгож байгаа бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 154,877.1 мянган төгрөг олгосон.
3.	Хөдөлмөрийн хортой нөхцөл, шөнийн болон илүү цагаар ажилласан, орон нутагт ажилласны нэмэгдэл хөлсийг хууль тогтоомжид заасны дагуу олгох	Жилдээ	2025 оны 11 дүгээр сарын 30-ний гүйцэтгэлээр БОШЛ-ийн 3 албан хаагчид хөдөлмөрийн хортой нөхцлийн нэмэгдэл 3,908. 0 мянган төгрөг, шөнийн болон илүү цагаар ажилласан нэмэгдэл 43 албан хаагчид 106,060.1 мянган төгрөг, орон нутагт ажилласны нэмэгдэл 66 албан хаагчид улсын төсвөөс 259,272.8 мянган төгрөг, мөн орон нутгийн төсвөөс 84,256.1

			мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг хууль тогтоомжийн дагуу тус тус олгосон.
4.	Орон нутагт томилолтоор ажиллах албан томилолтын зардлыг олгох	Тухай бүр	2025 онд албан томилолтын зардалд нийт 1,469.4 мянган төгрөг батлагдсан бөгөөд 11 гүйцэтгэлээр 11 албан хаагчид 1,469.4 мянган төгрөг олгосон.
5.	Ажлын байрны чиг үүргийг оновчтой тодорхойлох, ачааллыг жигдрүүлэх, албан хаагчдын ажлыг холбогдох журмын дагуу үнэлж, урамшуулах ажлыг зохион байгуулах	Хагас, бүрэн жилээр	2025 оны А/20 дугаар тушаалаар Үнэлгээний багийг томилж, албан хаагчдын эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх ажлыг зохион байгуулсан. Нийт 66 албан хаагчийг үнэлснээс 42 албан хаагч “Маш сайн”, 23 албан хаагч “Хэвийн”, 1 албан хаагч “Хангалтгүй” үнэлэгдэж, үнэлгээний тайланг мэдээллийн ил тодын веб хуудаст байршуулсан. Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг томилогдож чиг үүргийг шинжилгээ хийж, ажлын ачааллыг жигдрүүллээ. Жилийн эцсийн үнэлгээ хийх багийг байгуулж, журмын дагуу үнэлэх ажлыг зохион байгуулж байна.
6.	Төрийн албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид хөдөлмөрийн хуульд заасны дагуу ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгох	Жилдээ	2025 оны ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтын хуваарь, ажиллагсдын орлон ажиллах хуваарийг гаргаж батлуулсан бөгөөд албан хаагчид хуваарийн дагуу ээлжийн амралтаа эдэлж байна. Хангай, Булган сумдын хөдөө аж ахуйн цаг уурын харуулын техникчдэд биеэр эдэлж чадаагүй тус бүр 2 хоногийн амралтын цалинг хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журмамд заасны дагуу 1.5 дахин нэмэгдүүлж олголоо.
7.	Албан хаагчдын ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, гаргасан амжилт, идэвх зүтгэлийг үндэслэн төрийн дээд одон медаль, Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны тэргүүний ажилтан, жуух бичиг, Цаг уур, орчны шинжилгээний газрын жуух бичиг болон бусад салбарын шагналд тодорхойлох, тус төвийн шагналаар шагнах, мөнгөн шагнал, эд зүйл дурсгах	Жилдээ	Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга бөгөөд урьдчилан мэдээлэхийн технологич инженер С.Оюунбат 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр “Алтан гадас” одонгоор шагнагдсан. Мөн албан хаагчдын шагналын судалгааг excel файлаар төрийн албан хаагчийн анкетын дагуу шинэчлэн гаргасан.
8.	Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой байгуулсан Хамтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах	Жилдээ	Байгууллагын дэргэдэх “Хүүхэд гэр бүлийн зөвлөл”, “Залуучуудын зөвлөл”-тэй хамтран төвийн албан хаагчдын 15 хүртэлх насны 43 хүүхдэд гарын бэлэг гардууллаа.
9.	Албан хаагчдын хүүхдүүдийг “Хүүхдийн баяр”-аар хүлээн авч, бэлэг гардуулж, хүндэтгэл үзүүлэх	6 сард	Байгууллагаас Олон улсын хүүхдийн баярыг тохиолдуулан 4-5, 6-7 насны хүүхдүүдийн дунд “Хуйрнан шуугигч” бөхийн тэмцээн зохион байгуулж, 32 хүүхдийг гарын бэлэгээр шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан.
10.	2025 онд өндөр насны тэтгэвэрт гарах 2 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламжийг холбогдох журмын дагуу олгох	Тухай бүр	2025 онд 2 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахаар хүсэлтээ өгч 67,369.3 мянган төгрөгийн тэтгэмж батлагдсан. 11 дүгээр сарын байдлаар Сангийн яамнаас санхүүжилтыг олгоогүй хүлээгдэж байна.

11.	“Эцэг эхийн зөвлөл”, “Залуучуудын зөвлөл”-ийг ажиллуулах, үйл ажиллагааг нь дэмжих	Жилдээ	Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл” байгууллагын 0-16 насны хүүхдийн судалгааг шинчилсэн, олуулаа оролцоё уриалгад нэгдэж цахим сүлжээнд байршуулсан. Олон улсын хүүхдийн баярыг тохиолдуулан 0-16 насны хүүхдүүдэд гарын бэлэг гардуулсан.
Зорилт 3: Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэдэнд бие бялдар гоо зүйн төлөвшил олгох зорилтын хүрээнд:			
1.	Эрүүл мэндээ хамгаалах, төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээ, мэдээллийн булан ажиллуулах	Жилдээ	“Өглөөний алхалт-Таны эрүүл мэнд”-ын сарын аянд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцож Уур амьсгал хөдөө аж ахуйн цаг уурын боловсруулалт хариуцсан ахлах ажиглагч Д.Уранчимэг шагнагдсан. төрөлд Биеийн тамир, спортын тухай хууль “Алсын хараа -2050” урт хугацааны хөгжлийн бодлого, засгийн газар болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилд төвийн ажилчид хамрагдсан. Эцэг, эхийн зөвлөлийн самбарын эрүүл мэндийн буланд Эмчийн зөвлөгөө, тусламжаар бид хувь хүн болон гэр бүлийн эрүүл мэндийн бүхий л асуудал, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээ тогтмол шинэчлэн мэдээлж хэвшсэн. Аймгийн төвийн албан хаагчдыг 01 сарын 17-18 өдрүүдэд “Ар тооромт” эмнэлэгт эрт илрүүлэгт хамруулсан.
2.	Албан хаагчдыг спорт заалаар хичээллэх нөхцөл боломжоор хангах, спортын арга хэмжээ зохион байгуулах, оролцуулах, хамрагдах боломжоор хангах	Жилдээ	Байгууллагуудын албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулах, нийтийн бие тамирыг хөгжүүлэх, байгууллагын соёлыг бэхжүүлж идэвхтэй хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжиж МУБИС-ийн Архангай аймг дахь Багшийн сургуулийн спорт заалыг түрээслэж сард 1 удаа тоглож байна. “Дэлхийн болон Монголын Ус, Цаг уурчдын өдөр” 03 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд ажил мэргэжлээ сурталчилан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Орхон-Чулуут голын сав газрын захиргаа, Ар-Ус Ундарга ХХК, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар гэсэн 8 байгууллагын дунд шилжин явах цомтой, дардас, олс таталт, гар бөмбөгийн 3 төрөлт тэмцээнийг зохион байгуулж тэмцээнд амжилттай оролцож, БОШЛ-ын технологич инженер М.Чулуунхүү эмэгтэй дартсны тэмцээн Мөнгө, Урьдчилан мэдээлэхийн инженер С. Мөнхтөр эрэгтэй төрөлд дардас хүрэл, олс таталтаар багаараа хүрэл медаль тус тус авсан. Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025.05.01-ны өдрийн 01/618 тоотын дагуу “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяны хүрээнд албан хаагчдын эрүүл мэндийг идэвхтэй алхалт, дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор алхалтын аянд хамт олноороо идэвхтэй оролцлоо.
3.	Ажлын байранд дасгал, хөдөлгөөнийг хийлгэж хэвшүүлэх	Жилдээ	Сарын ажил хариуцан ажиллаж байгаа хэлтэс, салбар, хэсгүүд ажлын өдрүүдэд 11 цагт ажлын байранд дасгал, хөдөлгөөн хийлгэх ажлыг зохион байгуулж хэвшсэн.

			Мөн “Өглөөний алхалт”-ын сарын аянд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцож 1 хүн гарын бэлгээр шагнуулсан байна.
--	--	--	--

---oOo---

УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ



Web site:

<https://arkhangai.weather.gov.mn/>

<https://arkhangai.namem.gov.mn/>



Facebook page:

Архангай аймгийн Ус, цаг уур,
орчны шинжилгээний төв



Имэйл хаяг:

info@arkhangai.namem.gov.mn



Холбоо барих:

Утас ажил: 70332095

Хүний нөөц, бичиг хэргийн эрхлэгч Д.Гантуул

Холбоо барих утас: +976 88078301